

Төрөлжсөн хэлэлцээр хэрэгжүүлэх арга ажиллагаа

Ертөнцөд хүн төрдөг нь үнэн, татвар төлдөг нь үнэн билээ. Татвар төлөх нь хүний заяамал үүрэг, жам ёс, ёс ёмбогор, төр төмбөгөр гэхчилэн хууль ёсны утга агуулгаар хэрэгждэг болой. Татвар төлөх л бол зөвхөн үнэн зөв, голч шударгаар төлж занших нь үнэнийг дагасан бас нэгэн үнэн, үнэн юм үнэнээрээ л байх ёстой.

Монгол улс хэрэглээнийхээ бараа таваарын дийлэнхийг импортоор хангаж, улсын төсвийн орлогын 40 гаруй хувийг импортын гаалийн татварын орлогоор бүрдүүлдэг. Иймээс гаалийн албан татварыг үнэн зөв ногдуулах арга зүй, үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай олон улсын хэлэлцээр, монгол улсын гаалийн үнэлгээний журам зааварыг тодруулан тайлбарлах, ойлгуулах, учирлахыг энэ үгүүллийн зорилго болгож байна .

“Гааль” гэдэг нь улсын хилээр нэвтрүүлж гадаадаас оруулах, гадаадад гаргах бараанаас хураах “Татвар” гэсэн үг болохыг монгол хэлний тайлбар толин дээр тодорхойлсон байдаг. Монголчууд дээр үед “Гааль хураах” л гэдэг байж, өнөө бид гаалийн татвар хураах гэдэг болсон. Богд хаант монгол улсын үед гаалийг тусгай жишиг тогтоож хураадаг (тухайлбал , тодорхой тоо хэмжээний бараанд нэг хониор гааль хураадаг ч юмуу) байжээ. Манайхан татвар төлөхийг “Хаанд алба барих” гэдэг байсан нь төр нийгмийнхээ төлөө зүй ёсоор нь төлчихдөг нэр төрийн хэрэг гэвэл зохилтой.

Импортын бараанд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг тухайн барааг худалдаж авсан үнийн дүнгээс тооцдог учраас гаалийн татвар ногдуулах үнэ буюу “Гаалийн үнэ” гэдэг ойлголт бол бидний хувьд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үеээс бий болсон юм.

Яагаад гаалийн үнийн тухай зориуд тусгайлан авч үзэж байна вэ гэвэл, гаалийн татвар төлөгч олон арван мянган аж ахуй нэгж , байгууллага, иргэн бүр энэхүү үнийг холбогдох хэлэлцээр, журам зааврыг ягштал баримтлан үнэн зөв тодорхойлж, төлбөл зохих татварынхаа дүнг албан ёсны баталгаатай болгож, татвар төлөх үүргээ ёс төртэй биелүүлснээр улсын төсвийн орлогыг бүрдүүлэх , гадаад худалдааны статистик мэдээ гаргахад нэн чухал ач холбогдолтой болно. Гаалийн татвар ногдуулах нь төсвийн орлого бүрдүүлхийн зэрэгцээ импортын барааны хяналтыг ч нарийвчилж байгаа хэрэг.

1990, 2000-аад онд импортоор бараа оруулж ирдэг байгууллага, иргэд татвар төлөхдөө гаалийн үнийг хэрхэн тодорхойлох дүрэм журам, арга ажиллагааг төдийлөн ойлгодоггүй, анхаардаггүй, бараг л тоо тавих байдлаар хандаж, татвараа аль болох бага төлөх, зугтаах зэргээр гүйцэлдүүлэхийг хичээдэг, ер нь буруу зөрүү, төлдөг байсан гэхэд хилсдэхгүй. Татвараа багаханшиг төллөө (төлөх ёстойгоосоо дутуу төллөө), арай ч их төлчихлөө гэх мэтээр л ярьдаг байлаа. Гаалийнхан ч гэсэн гаалийн үнийг сайтар хянаж татварыг зөв ногдуулахтай холбогдох хууль эрхийн актыг хайхардаггүй, хөнгөн гоомой хандаж байсан. Тэр үед бэлэн мөнгөөр наймаа хийж байсан тохиолдол ч нэлээд байсан. Гаалийн татварыг буруу зөрүү төлбөл худалдаа бизнесийн үйл ажиллагаанд маш их сөрөг үр дагавартай. Татвараа төлөөгүй бол бүр ч гай гамшиг болно. Зөвхөн татвараа зүй ёсоор нь төлж улс орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэрээ оруулснаар л эдийн засгийн аливаа үйл ажиллагаа албан ёсных болно шүү дээ. Татвараа төлөөгүй, эсвэл буруу зөрүү төлчихбөл цаашаа гишгэх газаргүй болно гэж гадныхан ярьдаг юм. Өнөөгийн яриад байгаа их хэмжээний хууль бус орлого, мөнгө хөрөнгө гээд нийгэмд ихээхэн хор уршиг дагуулж буй сөрөг үйлдлүүд татвар төлөөгүй, албан бус үйл ажиллагаатай л холбоотой шүү дээ.

Гаалийн үнийг хэрхэн тодорхойлох асуудлаар Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр (ГАТТ 1994)-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай төрөлжсөн хэлэлцээр (гаалийн үнэлгээний хэлэлцээр) байдаг.

Гаалийн үнэлгээний хэлэлцээрийн зарим гол үг хэллэгийн утга санааг тайлбарлаж ойлгуулахыг хичээе. Хэлэлцээрт “Импортын барааны гаалийн үнэ” гэдэгт импортын барааны үнийн дүнгээс хувиар тооцож гаалийн татвар ногдуулах зорилгоор тодорхойлсон үнийг ойлгох бөгөөд энэхүү үнэ нь тухайн барааны “Хэлцлийн үнэ” дээр үндэслэнэ гэж заасан байгаа. Хэлцлийн үнэ бол гаалийн үнийг тодорхойлох суурь үндэслэл болох бөгөөд импортын бараанд төлсөн буюу, эсвэл төлбөл зохих “Бодит үнэ”(бодит баримтаар нотлогдсон үнэ) юм.

Төлсөн буюу, эсвэл төлбөл зохих бодит үнийг импортлосон бараанд худалдан авагчаас хийчихсэн буюу, эсвэл хийх ёстой төлбөрийг бүгдийг нь багтаасан төлбөр тооцооны дүн гэж ойлговол бас зохистой болно. Энэхүү төлбөр тооцоог бодит баримтаар баталгаажуулж импортлогчоос худалдагчид бүрэн төлж барагдуулах нь тодорхой. Ер нь баримтгүй төлбөр тооцоо ч гэж юу байх билээ.

Хэлэлцээрийн үг хэллэгийн утга агуулгыг сайтар ойлгож хэрэгжүүлэх учиртай. “Үг хэллэгийн утга санааг зөв ойлгох аваас хийж хэрэгжүүлэх ажлынхаа хагасыг нь мэдэж байна гэж үзэж болно” гэсэн оновчтой үг байдаг. Хэлцлийн үнэ буюу бодит үнэ гэдэг ойлголтыг үнэлгээний хэлэлцээрийн утгаар, англиар “Act”-“Actual value”, оросоор “Факт-Фактическая стоимость” гэж илэрхийлсэнийг ойлгоход хялбар байдаг. Act, Факттай дүйсэн үг хэллэгийг “Бодит баримт” гэсэн утгаар илэрхийлээд, акт баримтад тулгуурлаж (албан ёсны баримтаар баталгаажуулж), үнэлгээний дүрэм журмыг хэрэгжүүлэх гэж ойлговол тохиромжтой байгаа юм. Товчоор хэлбэл, экспортлогчоос импортлогч буюу татвар төлөгчид худалдан авсан барааныхаа үнийг нэхэмжилсэн баримт-“Invoice(падаан)” үнэн бодитой байх нь тодорхой. Үнэн бодитой гэдгийг экспортлогч орноос импортлогч оронд худалдсан барааны төлбөр тооцооны үнэн бодит баримт (аксиом) гэвэл ойлгомжтой болно. Гаалийн үнэ гэдэг “Үнэн”-ийг зөвхөн бодит баримтаар хүлээн зөвшөөрөх ёстой. Баримт жинхэнэ ёсоороо, үнэн мөнөөрөө л байгаа бол гаалийн үнийг тодорхойлоход ямар нэгэн тайлбар,хэн нэгийн хөндлөнгийн оролцоо, өөрөөр авч үзэх боломжгүй, утгагүй болно. Баримт бол баримт- бодит үнэний хэмжүүр гэдэг үүднээс хандах хэрэгтэй. Гаалийн үнийг үнэн бодит баримтаар нотлон мэдүүлж байгаа л бол татвар шууд “Ногоон гэрэл”-ээр төлөгдөнө. Ер нь худал хуурмаг баримт гэж юу байх юм бэ ? Экспортлогч худалдсан барааныхаа үнийг нэхэмжлэхдээ буруу баримт илгээх юмуу, импортлогч худалдаж авсан барааныхаа үнийг буруу төлөх юмуу. Огт утгагүй байгаа биздээ. 1990-ээд онд “Хуурамч баримт” гэх яриа байсан. Нөгөө бартерийн худалдаа, ганзагын наймаа гэх мэт асуудал өнөө байхгүй.

Үнэлгээний хэлэлцээрт заасан гаалийн үнийг тодорхойлох арга ажиллагааг товчлон авч үзье. Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд зааснаар тодорхойлсон хэлцлийн үнэ бол гаалийн үнийг тодорхойлох үнэмлэхүй үндэслэл мөн болохыг хуульчилсан байдаг. Ийм учраас гаалийн үнийг тодорхойлохдоо аль болохоор үнийг нь тодорхойлж буй барааны хэлцлийн үнийг үндэслэх ёстой гэдгийг хэлэлцээрийн зүйл заалт болгонд чухалчлан тусгасан байна. Хэлцлийн үнийг үндэслэн гаалийн үнийг тодорхойлохын тулд хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан, худалдан авагчийн зайлшгүй хариуцах тодорхой үнэ, төлбөрийг импортын бараанд төлсөн буюу, эсвэл төлбөл зохих бодит үнэд оруулж тооцоогүй байвал түүнийг нэмж тооцож энэхүү үнэд тохиргоо өөрчлөлт оруулна. Нэмж тооцох эдгээр үнэ төлбөрүүдээс заримыг дурдья: Төлсөн буюу, эсвэл төлбөл зохих бодит үнэд ороогүй бөгөөд худалдан авагчаас гаргасан хэмжээгээр дараах зардлууд-комиссийн шимтгэл болон зуучлагчийн шагнал; гаалийн зорилгоор импортын тухайн бараатай хамт нэгдмэл байдлаар авч үзэх чингэлэгийн үнэ; ажлын хөлс болон материалын үнийг аль алийг нь багтаасан баглаа боодлын үнэ. Үнийг нь тодорхойлж буй бараатай хамааралтай бөгөөд худалдан авагчаас хэлцлийн нөхцлөөр шууд ба шууд бус хэлбэрээр төлөх үүрэг хүлээсэн оюуны өмч ашигласны болон лицензийн хураамжийн төлсөн буюу, эсвэл төлбөл зохих бодит үнэд ороогүй хэсэг. Импортлож буй барааг цаашид дамжуулан худалдах, захиран зарцуулах, хэрэглэх

явцад олох орлогын худалдагчид шууд ба шууд бус байдлаар шилжих хэсэг. Мөн түүнчлэн худалдан авагчаас худалдагчид мөнгөн хэлбэрээр бус, тусгай бараа материал, ажил үйлчилгээний хэлбэрээр шилжүүлсэн, хэлцлийн үнэнд оруулж тооцвол зохих үнэ, төлбөрийн талаар тодорхой заалтыг 8-р зүйлд тусгасан байна. Ингэж 1-р зүйл нь 8-р зүйлтэй хамтдаа гаалийн үнийг тодорхойлох нэгэн нэгдмэл зохицлыг бүрдүүлнэ.

Гаалийн үнэд дараах үнэ, зардлыг бүрэн, эсвэл зарим хэсгийг оруулах, эс оруулахыг гаалийн үнэлгээний хэлэлцээрийн гишүүн орон өөрийн орны хууль тогтоомжоор шийдвэрлэнэ: Үүнд: импортлож буй барааг импортлогч орны оруулах боомт буюу газар хүртэл тээвэрлэсний зардал; импортлож буй барааг импортлогч орны оруулах боомт буюу газар хүртэл тээвэрлэх явцад гарсан ачих буулгах, шилжүүлэх ачих зардал; даатгалын хураамж.

8 дугаар зүйлд зааснаар төлсөн буюу, эсвэл төлбөл зохих бодит үнэд нэмэлт оруулахдаа зөвхөн тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн, бодитой мэдээлэл дээр тулгаарлана. Гаалийн үнийг тодорхойлохдоо төлсөн буюу, эсвэл төлбөл зохих бодит үнэд энэ зүйлд зааснаас өөр бусад ямар ч нэмэлтийг оруулж болохгүй.

1 дүгээр зүйлд зааснаар гаалийн үнийг тодорхойлох боломжгүй бол 2-7 дугаар зүйлд заасан аргуудаар тодорхойлно. Гаалийн байгууллага, импортлогч гаалийн үнийн мэдээллийн талаар харилцан зөвлөлдөж 2, эсвэл 3 дугаар зүйлд зааснаар гаалийн үнийг тодорхойлох үндэслэлийг гаргана. Тухайлбал, импортлосон ижил төрлийн буюу, эсвэл адил төрлийн барааны гаалийн үнийн талаар хангалттай баримт, мэдээлэл гаалийн байгууллагад хараахан бэлэн бус байхад импортлогчид байж болно. Нөгөө талаас импортлосон ижил төрлийн буюу, эсвэл адил төрлийн барааны гаалийн үнийн талаарх зохих мэдээлэл импортлогчид тухайн үед байхгүй, харин гаалийн байгууллагад байж болно. Хоёр тал гаалийн үнийг тодорхойлох үндэслэлийг гаргах үйл ажиллагааны явцад худалдааны нууцыг хадгалах шаардлагатай бөгөөд үнийн талаарх мэдээллийг зөвхөн гаалийн зорилгоор ашиглана. Ижил төрлийн бараа гэдэгт үнийг нь тодорхойлж буй бараатай бодит шинж байдал, чанар, нэр хүнд зэрэг бүх үзүүлэлтээрээ яг ижил барааг ойлгоно. Мэдээж, экспортлогч болоод үйлдвэрлэгч нь нэг л улс орон байх ёстой. Эдгээр үзүүлэлтүүдийг агуулж байвал гадаад үзэмжийн бага зэрэг ялгаа нь ижил төрлийн бараа гэж үзэхэд саад болохгүй. Адил төрлийн бараа гэдэгт үнийг нь тодорхойлж буй бараатай ижил биш боловч үндсэн шинж байдлаараа адил бөгөөд нэг ижил үүрэг гүйцэтгэх болон арилжааны хувьд харилцан орлох нөхцлийг бүрдүүлсэн, адил материалаас бүтсэн барааг ойлгоно. Бараа адил төрлийн байх шалгуурыг хангах хүчин зүйлд барааны чанар, нэр хүнд, барааны тэмдгийг тооцон хамруулах ёстой гэжээ.

Импортлосон тухайн барааны хэлцлийн үнэ, эсвэл түүнтэй ижил төрлийн буюу, эсвэл адил төрлийн барааны хэлцлийн үнийг үндэслэн гаалийн үнийг тодорхойлох боломжгүй бол 5,6 дугаар зүйлд заасан хоёр үндэслэлээр тодорхойлно. Түүнчлэн, хэрвээ импортлогч хүсвэл барааг импортлосны дараа дотоодын зах зээлд борлуулсан үнийг үндэслэн 5 дугаар зүйлд зааснаар гаалийн үнийг тодорхойлох эрхтэй. 6 дугаар зүйлд зааснаар гаалийн үнийг тодорхойлохдоо тооцооны үнэ дээр үндэслэнэ. 5,6 дугаар зүйлд зааснаар гаалийн үнийг тодорхойлоход тодорхой бэрхшээлтэй байдгийг харгалзан импортлогч энэ хоёр аргын дэс дарааллыг сольж хэрэглэх эрхтэй болохыг 4 дүгээр зүйлд заасан байна. Гаалийн үнийг дээр дурдсан зүйлүүдэд зааснаар тодорхойлох боломжгүй бол 7 дугаар зүйлд зааснаар тодорхойлно. 7 дугаар зүйлийн заалтуудыг авч үзье: хэрэв импортлогч үнийг нь тодорхойлж буй барааны гаалийн үнийг 1-6 дугаар зүйлд зааснаар тодорхойлох боломжгүй бол үнэлгээний хэлэлцээрийн ерөнхий зарчим, заалт болон ГАТТ-ын VII зүйлд нийцсэн ухаалаг арга ажиллагааг ашиглах замаар импортлогч орны бодит мэдээллийг үндэслэж тодорхойлно. Энэ зүйлд гаалийн үнийг тодорхойлохдоо үндэслэж үл болох үнийг тоочсон байна. Үүнд: импортлогч орон өөрийнхөө үйлдвэрлэсэн барааг дотооддоо худалдан борлуулсан

үнэ (дотоодын барааны борлуулалтын үнэ); гаалийн зорилгоор хоёр альтернатив үнээс илүү өндрийг нь сонгож авах систем; Экспортлогч орны дотоод зах зээлийн үнэ; тухайн барааг импортлож буй орноос өөр оронд экспортлоход хэрэглэдэг үнэ(экспортлогч орноос барааг гуравдагч оронд нийлүүлэхэд хэрэглэдэг үнэ); гаалийн доод үнэ; дурын буюу, эсвэл баттай нотлогдоогүй үнэ. Эдгээр болно.

Үнэлгээний хэлэлцээрт заахдаа: импортлогч буюу гаалийн татвар төлөгч аль нэг этгээд гаалийн үнэлгээний асуудлыг албадлага(мөрдөн байцаалт)-ын аргаар бус гомдол мэдүүлэх замаар шийдвэрлэх эрхтэй байхаар хэлэлцээрийн гишүүн орон бүрийн хууль тогтоомжоор хангаж өгөх ёстой; гомдлыг мөрдөн байцаалтгүйгээр эхлээд гаалийн холбогдох байгууллагад гаргах боловч импортлогч шүүхэд гомдол гаргах эрхтэй байхаар хэлэлцээрт оролцогч тал хууль тогтоомждоо заасан байх ёстой; гомдол гаргах болсон тухай шийдвэр, түүний үндэслэлийг бичгээр мэдэгдэнэ, мөн түүнчлэн гомдол мэдүүлэгч цаашид давж заалдах эрхтэй болохыг мэдэгдэнэ гэжээ.

Дэлхий даяар мөрдөж буй гаалийн үнэлгээний энэхүү төрөлжсөн хэлэлцээрийг үндэслэн гаалийн татвар зөв ногдуулах асуудлыг нэг мөр, үнэнч шударгаар хэрэгжүүлэх нь нэг талаас татвар төлөгч аж ахуй нэгж, байгууллага, иргэд, нөгөө талаас гаалийн байгууллага, байцаагчдын нэн чухал ажил хэрэг, улс нийгмийнхээ өмнө хүлээх өндөр хариуцлага байх ёстой.

Д.Дариа